

“ЭРДЭНЭС СИЛВЕР РЕСУРС” ХХК-ИЙН САЛХИТЫН УУРХАЙН ХААЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЖИШИГ ТӨСЛИЙН МЭДЭЭ


Дугаар 6 2022 оны 3-р сар

■ ЖИШИГ ТӨСЛИЙН 1-Р ҮЕ ШАТАНД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Салхитын ордын хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулах жишиг төслийн эхний үе шатны чухал бүрэлдэхүүн болох хаалтын нөхөн сэргээлтийн зорилго, зорилтуудыг тодорхойлох оролцогч талуудын хамтын ажиллагааны талаар өмнөх сарын мэдээнд танилцуулсан билээ. Хаалтын төлөвлөлт хийхэд гол хүчин зүйл болох нөхөн сэргээлтийн зорилго, зорилт боловсруулах нийт 7 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож, санал зөвлөмжөө хуваалцсан төслийн оролцогч талуудад MERIT төслөөс талархал илэрхийлж байна.

Хаалтын зорилго, зорилтыг оролцооны зарчмаар боловсруулж санал нэгдсэн. Зорилго, зорилтыг оновчтой тодорхойлох нь хаалтын дараах газар ашиглалтын зориулалтад нийцсэн нөхөн сэргээлт, стратеги арга замыг тодорхойлох, төлөвлөлтийн үр нөлөөг нэмэгдүүлэх зэрэг олон давуу талтай. Нөхөн сэргээлтийн зорилго, зорилтыг эрэмбэлэх, эцэслэн тодорхойлох зорилгоор хоёр удаагийн асуулга судалгааг цахимаар зохион байгуулав.

Хаалтын нөхөн сэргээлтийн үндсэн 2 зорилгын хүрээнд тусгайлсан болон нийтлэг зорилтуудыг эрэмбэлж, санал нэгдлээ. Салхитын ордын хаалтын төлөвлөгөөний зорилго, зорилтуудын уялдаа холбоог доорх зурагт үзүүлэв.



■ ХИЙГДЭЖ БУЙ АЖЛУУД

Төслийн эхний үе шат буюу ирэх 4-р сард багтаан дуусгахаар дараах ажлуудыг хийж байна. Үүнд:

ХААЛТЫН ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ



Эрсдэлийн удирдлага нь уурхайн хаалтын төлөвлөлтийн чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд ихэвчлэн нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөхийн өмнөх шатанд гүйцэтгэдэг. Эрсдэлийн шинжилгээ нь нөхөн сэргээлтийг үр дүнтэй гүйцэтгэхэд болзошгүй аюул эрсдэл болон боломжуудыг үнэлж, хаалтын төлөвлөлт, гүйцэтгэлийг тогтвортой хэрэгжүүлэх үндэс болдог.

Энэхүү эрсдэлийн шинжилгээ нь компанийн дотоод нөөц бололцоо, төсөв санхүү зэрэг хаалтын менежментийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэх төрөл бүрийн болзошгүй эрсдэлийн бүртгэл хийж, нөлөөллийн магадлалын талаар компанийн дээд түвшний удирдлагуудад танилцуулах, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах, эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Түүнчлэн хаалтын төлөвлөгөө боловсруулах баг нөхөн сэргээлтийг үр дүнтэй хийхэд үүсэж болзошгүй аюул бэрхшээл болон давуу талуудыг холбогдох шалгуур үзүүлэлтүүдтэй харьцуулан шинжлэх, эрсдэл бууруулах арга хэмжээг тодорхойлоход мэдээллээр хангах юм.

Төлөвлөгөө боловсруулагчид эрсдэлийн шинжилгээний үр дүнг ашиглан гадаргуугийн хэлбэржүүлэлт, технологийн шийдлийг тооцоолох болон хяналт мониторинг асуудлыг уурхайн хаалтын төлөвлөгөөнд тусгах боломж бүрдэнэ. Үүний зэрэгцээ уурхайн удирдлага нөхөн сэргээлтийн үр дүнг хэрэгжүүлэхэд шаардлагатай нэмэлт судалгаа шинжилгээ, технологийн шинэчлэлт, туршилтын арга хэмжээнүүдийг төлөвлөхөд мэдээллээр хангах ач холбогдолтой. Уг эрсдэлийн шинжилгээний үр дүнг дараа сарын мэдээнд илүү дэлгэрэнгүй танилцуулах болно.

■ ЗӨВЛӨХ СОНГОН ШАЛГАРУУЛАХ УУЛЗАЛТ

MERIT төслөөс жишиг төслийн 2 үе шатны бэлтгэл болгож техникийн баг бүрдүүлэх зөвлөх үйлчилгээ сонгон шалгаруулах уулзалтуудыг зохион байгуулав. Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулах техникийн баг нь геотехникийн инженер, хөрс, ус, ургамал, амьтан судлал болон нарийн мэргэжлийн судлаач, инженерүүдээс бүрдэнэ. Иймд үндэсний зөвлөхүүдийг сонгон шалгаруулж, хаалтын нарийвчилсан төлөвлөгөөний техникийн бүлэг тус бүрийг боловсруулахад Эрдэнэс Силвер Ресурс ХХК-тай хамтран ажиллах болно. Уг жишиг төслийг чадавх бэхжүүлэх үндсэн зарчимд суурилан хэрэгжүүлж буй учир техникийн багийн гишүүд төлөвлөгөө боловсруулах явцад олж авсан мэдлэг, туршлагаа дараа дараагийн хаалтын төслүүдийг боловсруулахад ашиглах чадавхтай болох юм.

■ ЖИШИГ ТӨСЛИЙН 2-Р ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

Дээрх үйл ажиллагаанаас гадна Салхитын хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулах 2-р үе шатны ажлын төлөвлөгөө, шаардлагатай зардлын тооцооллыг боловсруулж байна. Уг хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулах ажлын төлөвлөгөө нь нарийвчилсан техникийн даалгавар, талуудын оролцоог хангах арга хэмжээ, чадавх бэхжүүлэх сургалт, болон эдгээрийг хэрэгжүүлэх хугацаа зэрэг үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

ХОЛБОО БАРИХ

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл Төслийн дэд захирал *Р.Алтангэрэл* [✉ r.altangerel@merit.mn](mailto:r.altangerel@merit.mn)